



 **MCS** *Coca-Cola*[®]

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН -2023



Бидний тухай

04

- Өмнөх үг
- М-Си-Эс Кока-Кола ХХК-ийн тухай

Тогтвортой хөгжил

06

- Тогтвортой хөгжлийн зорилттой уялдах нь
- Тогтвортой хөгжлийн журмууд

Эх дэлхий

13

- Сав баглаа боодол ба хог хаягдал
- Ус
- Уур амьсгал

Бүтээгдэхүүн

27

- Бүтээгдэхүүний сонголт
- Тогтвортой ханган нийлүүлэлт

Хүмүүс

42

- Манай хүмүүс
- Олон нийт

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

“М-Си-Эс Кока-Кола” компани дэлхийд алдартай Кока-Кола ундааг эх орондоо 23 дахь жилдээ үйлдвэрлэн борлуулж, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн, шинэ технологи, бизнесийн арга ухаан, ноу-хауг нутагшуулан хөгжүүлж байна.

Бид тойрог эдийн засгийг бий болгоход өөрсдийн хувь нэмрээ оруулж, байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийнхээ цар хүрээг өргөжүүлж, олон нийтийн оролцоог улам нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

Тиймээс компанийн ирэх таван жилийн стратеги төлөвлөгөөний 6 үндсэн зорилтын нэг нь “Тогтвортой хөгжлийн манлайлагч” байх бөгөөд бүхий л үйл ажиллагаандаа **3R - REDUCE, RECYCLE, REUSE** буюу Бууруулах, Дахин боловсруулах, Дахин ашиглах зарчмыг баримтлан ажиллаж буй юм.

Тухайлбал:

- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг **25%**-иар бууруулах
- Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх усны зарцуулалтыг **1.7л** болгох
- Хуванцрын хаягдлыг дахин боловсруулж, дахин ашиглах замаар нийт бүтээгдэхүүний **28%** -ийг дахин боловсруулсан савлагаатай болгох
- Хэрэглэгчдэд сонголт бий болгож, жилдээ бага сахартай болон сахаргүй **1-2** бүтээгдэхүүн хөгжүүлэх
- Эрүүл, аюулгүй болон олон талт оролцоог дэмжсэн, **хүртээмжтэй** ажлын орчин бүрдүүлэх



Гүйцэтгэх захирал
Л. МЯГМАРЖАВ

Түүнчлэн, М-Си-Эс Кока-Кола компани хуванцар хаягдлыг ангилж ялгадаг тогтолцоог улс орон даяар бүрдүүлж, иргэдэд дадал болгон нутагшуулахаар “Хуванцрын Хаягдалгүй Дэлхий” кампанит ажлыг өнгөрсөн жилүүдэд өрнүүллээ. Үүний үр дүнд нийт борлуулсан PET-1 тэмдэглэгээтэй бүтээгдэхүүний хуванцар савны 40 хувийг буцаан цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгчээ.

Тайлант онд манай хамт олон

- “ТОП-100 ААН”-ийн 16 дугаарт эрэмбэлэгдэж,
- “Шилдэг Татвар төлөгч” байгууллагаар шалгарч
- “Тогтвортой хөгжлийн манлайлагч” -аар тус тус шалгарлаа.

Бидний хийж хэрэгжүүлсэн ажил танд олон санаа, сэтгэгдэл, аз жаргалын мэдрэмжийг өгч чадна гэдэгт итгэлтэй байна. “Дэлхийн брэндийг Монголдоо” хэмээх хүсэл эрмэлзлээр жигүүрлэсэн манай хамт олны амжилт ололт, үнэт зүйлс, баримталдаг зарчим, байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр хэрэгжүүлсэн ач холбогдол, нөлөө бүхий ажлуудыг энэхүү тайланд багтаан өргөн барьж буйг маань хүлээн авна уу.

БИДНИЙ ТУХАЙ

“М-Си-Эс Кока-Кола” ХХК нь 2001 оны 9-р сард “Кока-Кола” компанийн албан ёсны үйлдвэрлэгч болох гэрээг үзэглэснээр, Монгол Улс дэлхийн бусад улсуудтай адил “Кока-Кола” гэр бүлийн гишүүн болж, орчин үеийн зах зээлээс суралцах түүний бүрэлдэхүүн хэсэг болох үүд хаалга нээгдсэн юм.



Ажлын байр

987

Харилцагч


17'000+

Брэнд

21

Төрөл

160



7 УНДАА САВЛАХ ШУГАМ

Өдөрт **2 сая/л** бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай



95 ТҮГЭЭЛТИЙН МАШИН

Өдөрт **1700** дэлгүүрт түгээх хүчин чадалтай

2023 ОНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БАЙГАЛЬ ОРЧИН

2.19_л

1 л бүтээгдэхүүнд зарцуулж
буй усны хэмжээ

40%

Хуванцар цуглуулалт

61.7_{г_рСО₂/л}

1 л бүтээгдэхүүн
үйлдвэрлэхэд ялгаруулж буй
хүлэмжийн хийн хэмжээ

НИЙГЭМ

Ажлын байр

987

47% ▶ эмэгтэй удирдах
ажилтан

15'025 ▶ цагийн сургалт

3 ▶ бүсийн оффис

70

Төрлийн олон нийтэд
чиглэсэн үйл ажиллагаа

793_{сая}

Төгрөгийн ивээн тэтгэлэг,
хандив тусламж

ЭДИЙН ЗАСАГ

Төлсөн татвар шимтгэл

70.7_{тэрбум}

Сүүлийн 5 жилд төсөвт
төвлөрүүлсэн татвар

296.8_{тэрбум}

Хөрөнгө
оруулалт

55.6_{тэрбум}

Дотоодын
худалдан авалт

194_{тэрбум}

 **MCS** *Coca-Cola*[®]
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ



“ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 17 ЗОРИЛТ БА М-СИ-ЭС КОКА-КОЛА ХХК ”

НҮБ-ын 2030 он хүртэл хэрэгжүүлэх Тогтвортой хөгжлийн 17 зорилтоос М-Си-Эс Кока-Кола ХХК 13 зорилтод хамаарах ажлыг үйл ажиллагаандаа бодитоор хэрэгжүүлж байна.

17 зорилтоос  13 зорилт



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

3

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ



Нийт ажиллагсдынхаа эрүүл мэндэд анхаарал хандуулж урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулах, мэргэжлийн бариа засалчдыг ажиллуулахад жилд



267.4 сая
төгрөгийг зарцуулсан.

6

БАТАЛГААТ УНДНЫ УС, АРИУН ЦЭВЭРШҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ



Хаягдал Ус Цэвэршүүлэх Байгууламж нь үйлдвэрийн технологийн хаягдал усыг 100% буюу



180'000

орчим тонн ус цэвэршүүлсэн.

4

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



Тасралтгүй суралцагч байгууллага байх зорилгын хүрээнд ажилтан бүр өөрийн мэдлэг ур чадвараа сайжруулах, карьерын зорилтдоо хүрэхийн тулд ерөнхий болон мэргэжлийн ур чадварын сургалтуудад жилд давтагдсан тоогоор



6'301

гаруй ажилтан хамрагдсан.

8

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨРИЙГ ДЭМЖИХ



987

орчим ажилтныг ажлын байраар хангаж



өрсөлдөхүйц цалин, урамшуулал олгодог. Ажилтнуудаа болон тэдний гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудалд тогтмол анхааран ажиллаж байна.

5

ЖЕНДЕРИЙ ТЭГШ БАЙД ХАНГАХ



Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжиж 2030 он гэхэд удирдлагын багийн



50%

хүргэх зорилттой ажиллаж байна.

9

ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



Өндөр бүтээмжтэй, энерги, усны хэмнэлттэй орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлсэн



УНДАА САВЛАХ **4**

шугам ажиллаж байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

10

ТЭГШ БУС
БАЙДЛЫ
БУУРУУЛ

Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоос үл хамааран эрх тэгш оролцоог хангадаг.

11

ЭЭЛТЭЙ ХОТ,
ИРГЭДИЙН
ОРОЛЦООГ
ДЭМЖИХ

Хог хаягдлын менежментийг амжилттай хэрэгжүүлж, нийт хог хаягдлын **61%** -ийг дахин боловсруулалт хийдэг аж ахуй нэгж, хувь хүмүүст хүлээлгэн өгсөн.

12

ХАРИУЦЛАГАТАЙ
ХЭРЭГЛЭЭГ
ДЭМЖИХ

Байгалийн баялгийг үр ашигтай хэрэглэж, тогтвортой менежментийг бүрдүүлж ажиллаж байна. Монгол улс даяар Хуванцрын хаягдалгүй дэлхий кампанит ажлыг амжилттай хэрэгжүүлж, 2023 онд нийт хуванцрын **40%** -ийг дахин боловсруулсан.

13

УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
ҮР НӨЛӨӨГ
БАГАСГАХ

Хийн түлшээр ажилладаг уурын зуухыг ашиглалтад оруулснаар хүлэмжийн хийн ялгаруулалтыг жилд **4'800** тонноор бууруулсан. Үйлдвэрийн үйл ажиллагаанд **100%** цахилгаан сэрээт ачигч ашигладаг. Харилцагч дээр байрлуулсан нийт хөргөгчний **73%** нь байгальд ээлтэй хөргөлтийн бодистой.

15

ХУУРАЙ Г
ЭКО СИС
ХАМГААЛ

Цэвэршүүлсэн хаягдал усаар хотын ногоон байгууламжийн усалгаанд **13'519** тонн усыг үнэ төлбөргүй нийлүүлсэн. Энэ хэмжээгээр цэвэр усны нөөцийг хэмнэж байна.

16

ЭНХ ТАЙВАН,
ШУДАРГА
ЁСЫГ ЦОГЦЛООХ

Монгол улсын болон Олон улсын хууль дүрмийг сахин, авилгал хээл хахуулиас ангид байх зарчимтай ажиллаж байна.

17

ХӨГЖЛИЙН
ТӨЛӨӨХ
ТҮНШЛЭЛИЙГ
БЭХЖҮҮЛЭХ

Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх ажлыг дэмжиж мэдлэг, мэргэшсэн чадвар, технологи солилцох, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх олон талт түншлэлийг дэмжин ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЖУРМУУД

М-Си-Эс Кока-Кола ХХК нь Кока-Кола брэндийн албан ёсны үйлдвэрлэгчийн хувьд тус компанийн дараах бодлого журамд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг.

Үүнд:

- Кока-Кола компанийн үйл ажиллагаандаа мөрдөх шаардлагууд (KORE)
- Сургуулийн орчинд бүтээгдэхүүн худалдаалахад баримтлах бодлого
- Хариуцлагатай маркетингийн бодлого
- Нийлүүлэгчийн удирдамжийн зарчим
- Тогтвортой хөдөө аж ахуйн зарчмууд
- Согтууруулах ундааны Хариуцлагатай маркетингийн бодлого

THE
Coca-Cola
COMPANY

KORE



Мөн дээрхээс гадна олон улсын засаглалын болон эрсдэлийн удирдлагын COSO зарчим, Компанийн засаглалын ISO 32000 багц стандартуудыг тус тус удирдлага болгон үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байна. Компанийн зүгээс Комплаенсийн үйл ажиллагаанд тусгайлсан нэгж, ажилтан байхаас гадна түүний хараат бус, бие даасан, үр нөлөөтэй үйл ажиллагаа чухал болохыг анхаарч, уг нөхцөлийг хангах үүднээс:

- Комплаенсийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, тайлан, төсвийг ТУЗ*-аар хэлэлцүүлж, баталдаг;
- Комплаенсийн нэгж тогтмол хугацаанд Аудит эрсдэлийн хороонд үйл ажиллагааны тайлан, компани дээр гарсан болон учирч болзошгүй эрсдлийн талаар урьдчилан танилцуулж, авсан арга хэмжээний тайланг хүргүүлэх, ТУЗ*, түүний хороодын зүгээс уг үйл ажиллагаанд зөвлөмж хүргүүлэх, шаардлагатай үйл ажиллагаанд зааварчилгаа өгөх зэргээр нягт хамтын ажиллагаатай байх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох ТУЗ*-ын хороодын дүрэм журамд тусган хэрэгжүүлж байна.

ТУЗ* - Төлөөлөн Удирдах зөвлөл


ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЖУРМУУД

Компани мөн дотооддоо засаглалын бодлого журмуудыг батлан, мөрдөж ажилладаг.

Үүнд:

- Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого
- Бизнесийн үйл ажиллагаа, ёс зүйн дүрэм
- Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого, журам (Үүнд: төрийн байгууллагатай харилцах харилцаа, төрийн болон бусад этгээдэд бэлэг сэлт өгөх, авах харилцаа, хяналт, авлигаас сэргийлэх хөтөлбөр, менежментийн болон эрх бүхий этгээдийн үүрэг зэрэг харилцааг зохицуулсан, давтамжит сургалт, мөн уг журмын хэрэгжилтийг хангах үүднээс v2022 оноос эхлэн бэлэг сэлт авах, өгөх, авилгаас сэргийлэх мониторинг хийж байна.)
- Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас сэргийлэх, эдийн засгийн хориг арга хэмжээнд нийцүүлэх бодлого, журам

- Ёс зүйн зөрчлийг хянан шалгах журам (Шүгэл үлээгч мэдээллээ нууцаар гаргах боломж, мэдээллийг шалгах процесс, шүгэл үлээгчийн эсрэг аливаа арга хэмжээ авахгүй байх; ажилтан, нийлүүлэгч, харилцагч хэн бүхэн ёс зүйн зөрчлийн мэдээллийг хүлээн авах Спийк Аут Хотлайныг уг журмын дагуу ажиллуулж эхэлсэн.)



ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАРИЛЦАА



БОНЗ* - Байгаль орчин, Нийгэм, Засаглал



 MCS Coca-Cola

ЭХ ДЭЛХИЙ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХӨТЛӨХ 17 ЗОРИЛГО 2016-2030



УС

2010 ОНООС ХОЙШ

Үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэх байгууламж



УУР АМЬСГАЛ

2021 ОНООС ХОЙШ

Хийн түлшээр ажилладаг Уурын зуухны байгууламж



САВЛАГАА

2014 ОНООС ХОЙШ

Савны жин бууруулах төсөл
Хуванцар сав дахин боловсруулах үйлдвэр

М-СИ-ЭС КОКА-КОЛА ХХК-ИЙН 2030 ОНЫ ЗОРИЛТ

УС

ЗОРИЛГО

2023 ОНЫ ЯВЦ

Дахин ашиглалтын хэмжээ

100%

Дахин ашиглалтын хэмжээ

5% Усны зарцуулалт
2.19 л

УУР АМЬСГАЛ

ЗОРИЛГО

2023 ОНЫ ЯВЦ

Хүлэмжийн хийн ялгарлыг

25% бууруулна

61.7 ГР СО2/Л

САВЛАГАА

ЗОРИЛГО

2023 ОНЫ ЯВЦ

Сав цуглуулалт

100%

Дахин боловсруулсан

50% rPET

Сав цуглуулалт

40%

ХУВАНЦРЫН ХАЯГДАЛГҮЙ ДЭЛХИЙ

М-Си-Эс Кока-Кола компани үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, хэрэглээг багасгах, урт хугацаандаа бүтээгдэхүүний савлагааг **100** хувь дахин боловсруулах зорилгоор “Хуванцрын Хаягдалгүй Дэлхий” кампанит ажлыг эхлүүлээ.



Ингэснээр 2023 онд нийт борлуулсан PET-1 тэмдэглэгээтэй бүтээгдэхүүний хуванцар савны **40** хувийг буцаан цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн.




ХУВАНЦРЫН ХАЯГДАЛГҮЙ ДЭЛХИЙ

Хуванцар дахин боловсруулах төсөл нь хоёр үе шаттайгаар хэрэгжиж байна.

Эхний үе шат:

Хуванцрыг олон шат дамжлагатай угааж цэвэрлэн хэрчих бөгөөд хэрчдэсийг өндөр температурт хайлуулан, талсжуулж мөхлөг үйлдвэрлэж байна. Уг түүхий эдээр нэхмэлийн утас, гялгар хавтас гэх мэт олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тул үйлдвэрлэсэн мөхлөгөөсөө тодорхой хувийг экспортод гаргаж байна.



Хоёр дох үе шат:

Хоёр дахь хөрөнгө оруулалтаар хүнсний саванд хэрэглэх боломжтой rPET мөхлөг үйлдвэрлэж, дахин боловсруулсан хуванцрыг хүнсний зориулалтаар ашиглах боломж бүрдээд байна. Энэхүү мөхлөгийн чанарыг FDA баталгаажуулж, сертификат олгосон бөгөөд уг үйлдвэрлэлийн технологи нь Европын холбооны стандартаар баталгаажсан.



ХУВАНЦРЫН ХАЯГДАЛГҮЙ ДЭЛХИЙ

М-Си-Эс Кока-Кола ХХК, Ти-Эм-Эл ХХК, Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөл - Хуванцар дахин боловсруулах гинжин хэлхээг байгуулах гурван талт хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.



Хогоо ангилан ялгадаг Шилдэг СӨХ шалгаруулав.



“Playtime” хөгжмийн наадам, Үндэсний их баяр наадам гэх мэт томоохон арга хэмжээнүүдийн хуванцрын хаягдлыг цуглууллаа.




Хөдөө орон нутгаас Хуванцар цуглуулах систем сайжирч, оролцогч талуудыг нэмэв



НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Чуулганд хуванцар дахин боловсруулах үйл явцыг танилцуулсан үзүүлэн дэлгэж, ААН-үүдийг хогоо ангилан хаяхыг уриалав

ХУВАНЦАР САВНЫ ЖИН БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР



М-Си-Эс Кока-Кола компани 330 мл, 500 мл савлагаатай Вонаqua усны савны жинг бууруулан,



нийт 48 тн хуванцарын хэмнэлтийг бий болгосон.

БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫН ДОТООД МЕНЕЖМЕНТ

Компани болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг бөгөөд хоёрдогч түүхий эдээр хийсэн бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн хэсэгт байршуулан ашиглаж байна.



2023 ОНД ГАРСАН НИЙТ ХОГ ХАЯГДАЛ



нийт хог хаягдал

740,000 кг



Үүнээс дахин боловсруулсан

452'000 кг

61%

Дахин боловсруулж
буй үзүүлэлт




БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ШИЛЭН САВЛАГАА



ДАХИН ЭРГЭЛТ

97%



АШИГЛАЛТАД ОРСОН

2002 он




ДАХИН ЭРГЭЛТИЙН ШИЛ
АШИГЛАЖ БУЙ ХЭМЖЭЭ

1'850 тн/жил

УСНЫ ҮР АШИГТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

М-СИ-ЭС КОКА-КОЛА Үйлдвэрийн усны хэрэглээ



М-Си-Эс Кока-Кола ХХК нь “Усны үр ашигтай хэрэглээг дэмжих” хөтөлбөрийг байгуулагдсан цагаасаа хэрэгжүүлсээр ирсэн. 2023 оны байдлаар нэг литр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд **2.19** литр ус ашиглаж байна. Энэ зорилгоо тасралтгүй сайжруулж сүүлийн 10 жилийн хугацаанд **17%** -иар, өнгөрсөн жилтэй харьцуулахад 5% дээшлүүлэн ажиллаж байна.



ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС ЦЭВЭРШҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖ



М-Си-Эс Кока-Кола ХХК нь үйлдвэрийн үйл ажиллагаанд ашигласан бүхий л усаа цэвэршүүлэх байгууламжийг **2010 онд** ашиглалтад оруулсан.

99.9 хувийн цэвэршилттэй, загас хүртэл амьдрах боломжтой энэхүү ус нь дараах хоёр стандарт шаардлагыг хангадаг.

Цэвэршүүлж буй хэмжээ: Жилд

 **180'000** тн ус

Цэвэршүүлсэн усны

 **5%** хэрэглэдэг

MNS 4943:2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэрлэгдсэн бохир усны стандарт

MNS 6734:2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус, техникийн ерөнхий шаардлага



ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС ЦЭВЭРШҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖ

2023 онд
13'519тн
 гаруй усыг дахин ашиглажээ



Бетон зуурмагийн Эвт чулуу ХХК



М-Си-Эс Кока-Кола түгээлтийн машины угаалга



Хот тохижилтын газар ОНӨААТҮГ



Ногоон байгууламжийн усалгааны Бат Өндөр Хайрхан ХХК




“Ойжуулъя, арчилъя, хамгаалъя” аян

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ХҮЛЭМЖИЙН ХИЙ

ШУУД ЯЛГАРАЛ 65%

Суурин байгууламж




Явах машин механизм



Хөргөх хөлдөөх агааржуулах байгууламж

ШУУД БУС ЯЛГАРАЛ 35%



Худалдан авсан цахилгаан эрчим хүч

1 ЛИТР УНДАА ҮЙЛДВЭРЛЭХЭД ЯЛГАРУУЛЖ БАЙГАА ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

	2021	2022	2023
Ялгаруулсан хүлэмжийн хий /тн/	12'780 тн	13'450 тн	16'188 тн
1 л ундаа үйлдвэрлэхэд ялгаруулсан хүлэмжийн хий грСО ₂ /л	59 грСО ₂ /л	55 грСО ₂ /л	61.7 грСО ₂ /л
Өмнөх жилийнхээс буурсан хувь	-57%	-7%	9%



ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ НЬ

Авто ПО буюу цахилгаан сэрээт өргөгч

2014 онд шинэ агуулахад баттерей цэнэглэх хэсэгтэй болсноор газар ажилладаг байсан сэрээт өргөгчийг баттерейгаар ажилладаг болгосон.

Байгальд ээлтэй хөргөгч

Манай компани 12,000 орчим хөргөгч, хөргөлтийн тоног төхөөрөмжтэй бөгөөд үүний 73% нь байгальд ээлтэй хөргөлтийн бодис агуулсан байна.

Энергийн хэмнэлттэй шугам

Дэлхийд хүнсний тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр тэргүүлдэг Германы “Krones” үйлдвэрээс сав үлээх болон хөдөлгүүрт зарцуулах энергийн хэмнэлттэй 7-р шугамыг 2021 онд суурилуулан ашиглаж байна.

Хийн түлшээр ажилладаг уурын зуух

Монгол Улсад Хүнсний салбараас хамгийн анхны агаарын бохирдол үүсгэхгүй, байгальд ээлтэй хийн зуухыг ашиглалтад оруулж, түүхий нүүрсний хэрэглээг халсан үйлдвэр болсон. Ингэснээр хүлэмжийн хийн ялгаруулалтыг жилд 4800 тонноор бууруулж байна.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА 2030 ОНЫ ЗОРИЛТ

	2023 ОНЫ ЯВЦ	2030 ОНЫ ЗОРИЛТ
Цахилгаан сэрээт өргөгч	100% цахилгаан	100% цахилгаан
Байгальд ээлтэй хөргөгч	Нийт 12'000 хөргөгчийн 73% нь байгальд ээлтэй	100% байгальд ээлтэй
Түгээлтийн машин	Евро 5 хөдөлгүүртэй	Цахилгаан болгох

2023 онд орчны тоос, тоосонцрыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд:



Сул шороо, тоосонцор, зэрлэг ургамалтай байсан 1,100 м2 орчим талбайг зүлэгжүүлэв.



Автомашинны 8,600м2 шороон зогсоол асфальтан хучилттай болов.

УУР АМЬСГАЛ

ЗОРИЛГО

25% Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна

ЯВЦ

61.7 гр CO₂/л



Утаагүй уурын зуух



Сэрээт Өргүүр 100% цахилгаан



Байгальд ээлтэй хөргөгч



Түгээлтийн машин - Евро5



БҮТЭЭГДЭХҮҮН



БҮТЭЭГДЭХҮҮНИЙ СОНГОЛТ

1

Чихрийн хэмжээ
бууруулалт



2

Шинэ
бүтээгдэхүүн



3

Хэрэглэгчид
чихэргүй, чихэр
багатай
бүтээгдэхүүн
санал болгох




4

Хэрэглэгчийн
бүтээгдэхүүний
талаар
мэдлэгийг
сайжруулах



5

Хариуцлагатай
Маркетингийн
Бодлого



6

Хүнсний аюулгүй
байдал, чанар



ХЭРЭГЛЭГЧДЭД СОНГОЛТ БИЙ БОЛГОХ

Тогтвортой хөгжлийн бодлогыг бизнесийн бодлоготой уялдуулж, хэрэглэгчдэд чихэргүй болон чихэр багатай ундааг санал болгодог. Нийт 47 төрлийн амтны 9 амт нь чихэргүй, 13 амт нь **100 гр ундаанд ногдох чихрийн хэмжээ нь 5 хувиас бага** байна.

НИЙТ 47 АМТНААС

0 САХАР



COCA-COLA NO SUGAR
COCA-COLA PLUS



SPRITE NO SUGAR
SPRITE PLUS



BONAQUA
BONAQUA BUBBLE



MILLENIA STILL
MILLENIA SPARKLING



SCHWEPPE'S
SODA WATER



9 АМТ



5 ХУВИАС БАГА



BONAQUA 8+ BERRY
BONAQUA 8+ HONEY LEMON




OOHA LYCHEE LACTIC
OOHA YUZU SEA SALT
OOHA PEACH OOLONG TEA



PUNCH APPLE
PUNCH MANGO
PUNCH BLACKGURRANT



FANTA PINEAPPLE
FANTA GRAPE
FANTA PEACH
FANTA ORANGE




POWERADE
SILVER CHARGE



13 АМТ



ХЭРЭГЛЭГЧДЭД СОНГОЛТ БИЙ БОЛГОХ



- М-Си-Эс Кока-Кола ХХК нь Хэрэглэгчдэд сонголтыг бий болгох зорилгоор 2018 оноос хойш нийт 9 төрлийн амтны чихрийн хэмжээг бууруулжээ.
- Цаашид жил бүр нэгээс хоёр ундааны чихрийн хэмжээг бууруулах зорилт тавиад байна.

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

1

PUNCH 450ML

2023.3

- Punch Хад жимс



САХАР
БАГАТАЙ

2

ООНА 480ML

2023.7

- Оона Личи, Лактик
- Оона Юзү жүрж, далайн давс
- Оона тоор, уулонг цай



САХАР
БАГАТАЙ

3

CRAFTEA 500ML

2023.9

- Craftea Тоор
- Craftea Нимбэг



VIO MILLENIA ҮЙЛДВЭР АШИГЛАЛТАД ОРЛОО

“Vio Millenia” байгалийн эрдэст ус нь Монгол орны онгон дагшин нутагт, газрын гүнд хуримтлагдах явцдаа үе давхаргуудад байрлах хөрс чулуулгаар эрдэсжсэн бүтээгдэхүүн юм. Дэлхийн 200 гаруй улсад бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг Кока-Кола компанийн албан ёсны брэнд Vio нэрийн дор үйлдвэрлэж борлуулах эрхийг авсан Монголын анхны бүтээгдэхүүн Millenia брэндийн үйлдвэр Сэлэнгэ аймагт ашиглалтад орлоо.



Бүтээгдэхүүний талаарх

ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЛЭГИЙГ САЙЖРУУЛАХ

Хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэх “Та үүнийг мэдэх үү?” цуврал контентыг манай компани хэрэглэгчдэд тогтмол хүргэдэг.

Шошгоны мэдээллийг хэрхэн унших талаар хэрэглэгчид мэдлэг олгох нь бидний зорилго юм.

“Та үүнийг мэдэх үү” цувралын хүрээнд хэрэглэгч өдөрт авч буй илчлэгийн хэмжээгээ тооцоолоход шошгоны мэдээлэл хэрхэн тусалж буй тухай тайлбарласан байдаг.

Монгол хүний жишсэн дундаж илчлэгийн хэрэгцээ хоногт 2400 ккал байдаг бөгөөд үүнээс 100 мл ундаа тутамд агуулагдах илчлэгийн хэмжээг шошгон дээр тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн хэрэглэгч шошгоны мэдээллээс бусад орц найрлагын мэдээлэлтэй танилцахаас гадна харшил үүсгэгч агуулсан эсэх талаар шошгоны мэдээллээс авах боломжтой.



#ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАР

“М-Си-Эс Кока-Кола” компани нь дэлхийн Кока-Кола компанийн албан ёсны франчайзинг эрхтэй учраас тэр хүрээнд тус компанийн шаардлагыг баримталж, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг өндөр түвшинд хангаж, үйлдвэрлэл эрхэлдэг.



“КОКА-КОЛА” КОМПАНИЙН БАРИМТАЛДАГ ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦОО

ЧАНАРЫН ЗАГВАРЧЛАЛ

Бүтээгдэхүүн хөгжүүлэлтээс эцсийн бүтээгдэхүүн хүртэл

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОГТОЛЦОО

Дэлхийд зөвшөөрөгдсөн ханган нийлүүлэгчид

ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүхий л үе шатанд давхар баталгаажуулалт


ЧАНАРЫН ЗАГВАРЧЛАЛ

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүхий л явц, урсгалд чанарын шаардлага бүрэн хангасан байх нь “Кока-Кола” компани үйлдвэрлэл эрхлэгчдийнхээ үйл ажиллагаанд тавьдаг нэн тэргүүний шаардлага юм. Үүнд, агаарын урсгал зүй зохистой байхаас эхлээд үйлдвэрлэлийн шат дамжлагад бүрэн нийцсэн барилга байгууламж барьж, үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн манай бүтээгдэхүүнийг худалдаалж буй иргэн, аж ахуйн нэгжийг шаардлага хангасан орчин нөхцөлд бүтээгдэхүүн худалдаалах, хадгалах шаардлага тавьдаг.



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАР

“М-Си-Эс Кока-Кола” компани олон улсын таван стандарт нэвтрүүлэн хэрэгжүүлдэг. Ингэхдээ жил бүр олон улсын гэрчилгээ олгох эрх бүхий “SGS” болон бусад байгууллагын аудитын шалгалтад хамрагдаж, гэрчилгээ эзэмших эрхээ тогтмол баталгаажуулдаг.



М-СИ-ЭС КОКА-КОЛА КОМПАНИЙН НЭВТРҮҮЛСЭН ОЛОН УЛСЫН БОЛОН МОНГОЛЫН СТАНДАРТУУД

ISO 9001:2015	Quality management systems Requirements	Чанарын удирдлагын тогтолцоо
MNS ISO IEC 17025:2018	MNS Mongolian national standard IEC-International Electrotechnical Commission	Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага
FSSC 22000 Version 5.1	Food safety system certification	Хүнсний аюулгүй байдлын системийн гэрчилгээ
ISO 14001:2015	Environmental management	Байгаль орчны менежмент
OHSAS 18001	Occupational Health and Safety Assessment Series	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үнэлгээний цуврал
ISO 45001	Occupational health and safety	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал

ХАРИУЦЛАГАТАЙ МАРКЕТИНГИЙН БОДЛОГО



13

аас доош насны хүүхдэд чиглэсэн маркетингийн хөтөлбөр хэрэгжүүлэхээс татгалзана

Тухайн сувгийн нийт хэрэглэгчийн

30%

13-аас доош насны хүүхэд эзэлж байвал

Манай компани хүүхдэд шууд чиглэсэн маркетинг хэрэгжүүлэхээс татгалзах бодлогыг цаг үргэлж баримталсаар ирсэн. Энэ хүрээнд бид хэрэгжүүлж буй маркетингийн хөтөлбөр бүрдээ анхаардаг бөгөөд Сургуулийн орчинд бүтээгдэхүүн худалдаалах бодлогыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцүүлэн баримталж байна.

“ ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ ”

М-Си-Эс Кока-Кола ХХК нь дэлхийн Кока-Кола компанийн зөвшөөрөгдсөн нийлүүлэгчдээс ус, ундаа үйлдвэрлэлийн түүхий эд, туслах материал, сав баглаа боодол зэрэг шууд болон шууд бус түүхий эд, бараа материалаа татан төвлөрүүлдэг.

Тухайн зөвшөөрөгдсөн нийлүүлэгч нь байгаль орчин, чанар, хүнсний аюулгүй байдлын тогтолцоонд мөрдөгддөг шаардлагыг бүрэн хангасан байдаг. Мөн урт хугацаанд тогтвортой, найдвартай ханган нийлүүлэх чадвар чадамжтай байх зэрэг олон төрлийн шалгуур шаардлагуудыг хангасан байдаг.



ХУДАЛДАН АВАЛТЫН БОДЛОГО, ЖУРАМ

Мөн М-Си-Эс группын хэмжээнд хэрэгжүүлдэг Худалдан авалтын бодлогыг манай компани баримталдаг.



Нийлүүлэгчдийг сонгон шалгаруулахдаа НҮБ-ын “Даян Дэлхийн гэрээ”-нд тусгагдсан дараах 10 зарчмыг гол үзүүлэлт болгон авч үзнэ.



1 Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг дэмжин хүндэтгэх



3 Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх



5 Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоох



7 Бизнесийн үйл ажиллагааг байгаль орчны шаардлагуудад нийцүүлэн урьдчилан сэргийлж ажиллах



9 Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэн нэвтрүүлэх



2 Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх



4 Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах



6 Хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн хүрээнд ялгаварлан гадуурхах явдлыг арилгах



8 Байгаль орчны хариуцлагыг дээшлүүлэх санаачилгыг нэвтрүүлэх



10 Авилга, хээл хахуулийн бүх хэлбэрийн эсрэг тууштай ажиллах

ХУДАЛДАН АВАЛТЫН 2023 ОНЫ ҮЗҮҮЛЭЛТ БА ЗОРИЛТ

ХУДАЛДАН АВАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

921 ▶▶ 777

2023 онд нийт 921 бэлтгэн нийлүүлэгчээс бараа, үйлчилгээ худалдан авснаас 777 нь буюу 84.3% нь дотоодын компани байсан.

194 ТЭРБУМ
ТӨГРӨГ



Дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс нийт 194 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

43% ДОТООД
ХУДАЛДАН
АВАЛТ



Нийт хийсэн худалдан авалтын 43% нь дотоодын худалдан авалт байв.

ХУДАЛДАН АВАЛТЫН ЗОРИЛТ



Тогтвортой хөгжлийн бодлого стандарт хэрэгжүүлэгч нийлүүлэгчдийг дэмжин ажиллана

Дотоод болон гадаад нийлүүлэгчдээс хийх худалдан авалтын шийдвэртээ тогтвортой хөгжлийн бодлого, стандартыг харгалзан үзэж шийдвэр гаргадаг болно.



Тогтвортой хөгжлийн нэгдсэн зорилтоо хамтран биелүүлэх зарчмаар ажиллана

Дотоод болон гадаад нийлүүлэгчдээс хийх худалдан авалтын шийдвэртээ тогтвортой хөгжлийн бодлого, стандартыг харгалзан үзэж шийдвэр гаргадаг болно.



Тогтвортой хөгжилтэй холбогдох судалгаа хийнэ


Дотоодын болон гадаадын ханган нийлүүлэгчдээс Тогтвортой хөгжлийн судалгаа авч, гадаадын ханган нийлүүлэгчдийн судалгааны хамрах хүрээг 50% хүртэл нэмэгдүүлнэ.



 MCS *Coca-Cola*



МАНАЙ ХҮМҮҮС

МАНАЙ ХҮМҮҮС




Ажиллах орчин
ба ажилтнууд

Олон янзат
байдал ба
хүртээмжтэй
ажлын байр



Сургалт хөгжил
ба чадавх
бэхжүүлэх

Сайн дурын үйл
ажиллагааг
дэмжих



АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОЛТ

НИЙТ АЖИЛТАН **987**



267

Эмэгтэй ажилтан

Нийт эмэгтэй
удирдах ажилтан

15



33

Нийт удирдах ажилтан

Шууд бусаар бий болгож
буй ажилтны тоо

16'113



33

Хөгжлийн бэрхшээлтэй
ажилтан

НИЙТ АЖИЛТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

2023

Ажилтны сэтгэл
ханамж

4.22/ 5

2022

Ажилтны сэтгэл
ханамж

4.37/ 5

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

НИЙТ АЖИЛТНЫ ▶ **28%**

УДИРДАХ АЖИЛТНЫ ▶ **47%**



ЭМЭГТЭЙ УДИРДАХ
АЖИЛТАН

2023 ОН


47%

2030 ОН

50%

ОЛОН ТАЛТ ЯЛГААТАЙ БАЙДАЛ

НАСНЫ АНГИЛАЛ



САЙН ДУРЫН ЗӨВЛӨЛ

ЗАЛУУЧУУДЫН ЗӨВЛӨЛ

- Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа
- Залуучуудын идэвх, оролцоо



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗӨВЛӨЛ

- Эмэгтэйчүүдийн манлайлал
- Эмэгтэй ажилтнуудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх



БҮТЭЭМЖИЙН ЗӨВЛӨЛ

- Ажилтны сэтгэл ханамжийг дээшлүүлэх
- Бүтээмжийг нэмэгдүүлэх

Усны алдагдал мэдээлэх хуудас



СПОРТЫН ЗӨВЛӨЛ

- Байгууллагын спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Эрүүл, спортлог амьдралын хэв маягийг түгээх



ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ

- Хүүхдэд ээлтэй байгууллага, хамт олныг бий болгоход дэмжих
- Хүүхэд хамгааллын бодлого



АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛ, ТАВ ТУХ

Манай үндсэн оффис хотын зүүн захад буюу Амгалан орчимд байрладаг. Тиймээс хүртээмжтэй ажлын байрыг бий болгох зорилгоор хотын баруун болон зүүн бүсийн оффисыг ажиллуулж эхлэв.



УЯН ХАТАН
ЦАГИЙН ХУВААРЬ

7⁰⁰-10⁰⁰ ➔ 16⁰⁰-19⁰⁰



Баруун оффис



Төвийн оффис




Зүүн оффис

Ажилчдын автобус



Мэргэжлийн бариач



ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

Ажилтнуудын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжтой томоохон бүтээн байгуулалтыг хийлээ.



Спорт заал

Олон улсын стандарт шаардлага бүхий спорт заал нь ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэнддээ анхаарах боломжийг олгож байна.



Дасгалын өрөө

Энэхүү өрөөнд Гүйлтийн зам, спиннинг зэрэг Фитнесийн төхөөрөмжүүд суурилуулснаас гадна йога хийх зай талбайтай гэдгээрээ онцлог юм.



Эх хүүхдийн өрөө

Уг өрөө нь хөхүүл болон жирэмсэн ээжүүд тухлан суух зориулалтын өрөө бөгөөд бусдаас ичихгүй, тухтай орчинд хүүхдээ хөхүүлэх, хөхөө саах боломжтой юм. Түүнчлэн эцэг эхээ хүлээх хүүхэд багачууд хичээлээ хийх боломжтой.

Олон сонголттой хоолны газар



Караоке өрөө



БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ ЦЭЦЭРЛЭГ

“М-Си-Эс Кока-Кола” компани БШУЯ-ны санаачилгыг дэмжиж, 75 хүүхдийн ортой байгууллагын дэргэдэх цэцэрлэг байгуулсан билээ. Нийт ажилтны 43 хувь нь 2-5 насны хүүхэдтэй тул цэцэрлэг байгуулах замаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэхэд ийнхүү хувь нэмрээ оруулж байна.



ОЛОН ТАЛТ БАЙДАЛ БА ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх тэгш ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор онцлог, ялгаатай байдалд нь тохирсон ажлын байр бий болгоход анхаардаг.

Манай компанид харааны, сонсголын болон бусад хөгжлийн бэрхшээлтэй 33 ажилтан бүтэн болон бүтэн бус цагаар ажиллаж байна.

Хамтран ажиллаж байгаа ажилтнуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудтай харилцах тал дээр шинэ туршлага хуримтлуулж байгаа төдийгүй тэдэнд зориулсан хүртээмжтэй сургалтыг зохион байгуулж байна.

АЖЛЫН БАЙРНЫ ҮНЭЛГЭЭ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллаж буй орчинд тохируулсан ажлын байрны үнэлгээг хийж, зохих арга хэмжээг авч ажиллав.

Үнэлгээний үр дүн:

Коридорын хэмжээ 251см, шалны гадаргуу нэг түвшинд байдаг учир харааны бэрхшээлтэй иргэнд зориулсан хөтөч бариул хүртээмжтэй.

Байгууллагын удирдлагуудын 80% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохирох хэрэглэгдэхүүний талаар мэдээлэлтэй байдаг.

Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд ажлын байран дээр хамт олны дунд илт ялгаварлан гадуурхалд өртдөггүй гэж хариулсан.



СУРГАЛТ, ХӨГЖИЛ, ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ

169
НИЙТ
СУРГАЛТЫН ТОО


152
ТАНХИМААР

17
ОНЛАЙН




15'025

ЦАГ СУРГАЛТАНД
ХАМРАГДСАН



ДОТООД СУРГАЛТЫН ПРОГРАММ

Компанийн Дотоод сургалтын “CokeLearn” LMS-ийг хөгжүүлж мэргэжлийн болон суурь ур чадварыг хөгжүүлэх сургалтуудыг зохион байгуулахаар ажиллаж байна.



СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР



MCS Academy-н сургалтуудад LMS-ээр ажилтан өөрөө хүсэлтээ илгээж, суралцдаг дадал бүрэн тогтсон.

ЦАЛИНТАЙ ДАДЛАГАЖИХ ХӨТӨЛБӨР

Оюутан залууст ажлын бодит туршлага хуримтлуулж, ажлын гарааны суурийг цогцоор нь зөв эхлүүлэх боломж олгохоор “MCS Internship” цалинтай дадлагажих хөтөлбөр 2022 оноос хэрэгжиж эхэлсэн

Уг хөтөлбөрийн хүрээнд 2023 онд манай компанид дөрвөн оюутан дадлагажигчаар ажиллалаа.



ЗАЛГАМЖ ХАЛАА, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Ирээдүйд ажиллах хүчээ бэлтгэх зорилгоор Их дээд сургуулийн оюутан залууст мэргэжлийн чиг баримжаа олгох, хэрхэн амжилттай ярилцлага өгөх, өөрийгөө хэрхэн илэрхийлэх сэдвийн хүрээнд сургалт орлоо. Түүнчлэн их дээд сургуулийн олимпиадад Тэргүүн байр эзэлсэн шилдэг оюутанг ажилд авлаа.



САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ

Ажилтан сайн дурын үндсэн дээр ESV (Ажил олгогчийн дэмжлэгээр сайн дураар ажиллах) хөтөлбөрийн хүрээнд нийгэм, байгаль орчинд тустай сайн дурын үйлсэд оролцох бол удирдлагын зөвшөөрлөөр жилд 1 өдрийн буюу 8 цагийн цалинтай чөлөө олгох журам хэрэгжүүлэн ажиллаж байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Манай компани 2023 онд нийт


70

төрлийн үйл ажиллагаа, байгууллагад

793

сая төгрөгийн хандив тусламжийг нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон байна.

Хандив тусламж олгосон САЛБАРУУД



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

"ХАНЖОУ 2022" АЗИЙН СПОРТЫН XIX НААДАМ

БНХАУ-ын Ханжоу хотноо болсон “Ханжоу 2022” Азийн XIX наадмыг ивээн тэтгэж, хамтран ажиллалаа.



ЖЮУ ЖИЦҮГИЙН 20 ДАХЬ ДАШТ

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 2023 оны 7 дугаар сарын 14-20-ны өдрүүдэд жюу жицүгийн насанд хүрэгчдийн 20 дахь удаагийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн амжилттай болж өндөрлөсөн.



ОУЖЖХ-ноос 2022 оны дөрөвдүгээр сард 20 дахь удаагийн жюу жицүгийн ДАШТ-ийг манай оронд зохион байгуулах эрхийг өгсөн бөгөөд уг тэмцээний ивээн тэтгэж хамтран ажиллав.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

МУИС-ИЙН ЦАХИМ СУРАХ БИЧГИЙН ТӨСЛИЙГ ИВЭЭН ТЭТГЭЛЭЭ

МУИС-ийн байгалийн ухааны салбарын эрдэмтэн багш нарын 20 гаруй бүтээлийг цахим хэлбэрт хөрвүүлж буй “Нээлттэй сурах бичиг” төслийг ивээн тэтгэв. Ховордсон сурах бичгүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь боловсролын тэгш хүртээмж бий болгоход эерэг нөлөөлөхийн сацуу сурлагын чанарыг ахиулах, багш эрдэмтдийн бүтээлийг боловсролын үнэт өв болгон хадгалах, багш оюутнуудын зайнаас ажиллаж суралцах боломжийг нэмэгдүүлэх зэрэг маш олон давуу тал, ач холбогдолтой билээ.



ТУСГАЙ ОЛИМПИЙН БАГ ТАМИРЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ

Оюуны бэрхшээлтэй залуусыг спортоор дамжуулж эрүүл чийрэг болгох, бие бялдрыг нь хөгжүүлэх зорилготой Тусгай олимпийн наадмыг “М-Си-Эс Кока-Кола” компани тогтмол дэмжигч, найдвартай түнш бөгөөд тамирчдын спорт хувцас хэрэглэл, бэлтгэлийн үеэр хэрэглэх ус, ундаанд дэмжлэг үзүүллээ. ХБНГУ-ын нийслэл Берлин хотод зохион байгуулагдсан уг тэмцээнд 9 төрөлд 44 тамирчин оролцсон билээ.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

UB MARATHON 2023

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Улаанбаатар Марафон 2023” олон улсын гүйлтийн арга хэмжээ 30.000 гаруй оролцогчтой болж өндөрлөсөн. Уг арга хэмжээнд Powerade брэнд хамтран ажиллалаа.



“SPRITE 3X3” ТЭМЦЭЭН

Үндэсний Соёл Амралтын хүрээлэнд байрлалтай “3x3 Garden” талбайд “SPRITE 3X3” Сагсан бөмбөгийн тэмцээнийг 17 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Уг тэмцээнд 1024 баг Улаанбаатар хот болон Дархан хотноо 8 өдрийн турш хурд хүч, авхаалж самбаа сорин өрсөлдөв.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

“PLAYTIME 2022” ХӨГЖМИЙН НААДАМ

21 дахь жилдээ зохиогдож буй Монголын хамгийн том амьд хөгжмийн наадам болох “Плейтайм фестиваль”-д ООНА брэндийг 70 мянган залууст танилцууллаа.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ “М-СИ-ЭС КОКА-КОЛА”

гPET үзүүлэнгийн хэсэг ажиллуулж, ус ундааны хуванцар сав болон бөглөөг дахин боловсруулж бүтээсэн түлхүүрийн оосрыг залууст тараалаа.



ДАХИВАР АВАХ ЯВУУЛЫН СТАНЦ БУЮУ “ДАЯС” ӨДӨРЛӨГ

Манай компани Дахивар авах явуулын станц буюу ДАЯС өдөрлөгийн нэг удаагийн арга хэмжээг хамтран зохион байгуулах байдлаар 2022 оноос оролцож эхэлсэн. 2023 оны ДАЯС өдөрлөгийн үеэр PET хуванцар ангилан ялгаж, цуглуулсан “Шилдэг Сууц Өмчлөгчдийн Холбоо”-г шалгаруулж, “Хуванцрын Хаягдалгүй Дэлхий” хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр урамшуулав. Түүнчлэн компанийн 8 алба хэлтэс сайн дураар хуванцрын хаягдлаа цуглуулж хүлээлгэн өглөө.

8 АЛБА ХЭЛТЭС ➤ 730 КГ ХУВАНЦАР



ШИЛДЭГ СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООД



ЦУГЛУУЛСАН ХУВАНЦРЫГ ЖИНЛЭЖ БУЙ НЬ



ХУВАНЦАР ЦУГЛУУЛАХ ЦЭГ

ҮЙЛДВЭРТЭЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ

НИЙТ 62 АЯЛАЛ

25

БАЙГУУЛЛАГА

16

ЕБС

21

ИХ СУРГУУЛЬ

1850 аялалд оролцогсод

Үйлдвэртэй танилцах аялал нь “М-Си-Эс Кока-Кола” ХХК-ийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах, хэрэглэгчдийг бүтээгдэхүүний талаарх зөв мэдээллээр хангах, шимтэн уух дуртай бүтээгдэхүүн нь хэрхэн үйлдвэрлэгдэн тэдний гар дээр очдогийг өөрсдийн нүдээр харах боломжийг олгохоос гадна, өөрийн компанийн байгаль орчинд чиглэн хийж буй үйл ажиллагаагаар дамжуулан өсвөр насны хүүхдүүдийн экологийн боловсролыг дэмжих зорилготой хөтөлбөр юм.

2023 онд Үйлдвэртэй танилцах аялалд 1850 оролцогч хамрагдаж, үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа.



Тогтвортой хөгжлийн чиглэлээр хамтран ажилдаг байгууллагууд



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР



БАТ ӨНДӨР
ХАЙРХАН



ХЭВ
ХАШМАЛ
ХХК

Хамтран ажилладаг Төрийн болон Төрийн бус байгууллагууд



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ҮНДЭСНИЙ
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТӨВ



СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР



ЗАСАГЛАЛ

БҮТЭЦ, ТОГТОЛЦОО

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

ЁС ЗҮЙН ХОРОО

БОНЗ-ЫН БАГ

ЭРСДЭЛИЙН ХОРОО

Чиглүүлэх, шийдвэр гаргах түвшин

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

БОНЗ-ЫН БОДЛОГО

ДОТООД АУДИТ

СПИЙК АУТ

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАРИЛЦАА

НИЙЦЛИЙН ТОГТОЛЦОО

ТАЙЛАГНАЛЫН ТОГТОЛЦОО

ЭРСДЭЛИЙН ТОГТОЛЦОО

Удирдах менежментийн түвшин

Зорилго, зорилт, стратеги, үзүүлэлтүүдээ тодорхойлно

Чадавх бэхжүүлэх сургалт хөгжил, хөтөлбөр

Нээлттэй, ил тод тайлагнал

Үйл ажиллагааны түвшин

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

ЕРӨНХИЙ ЭРСДЭЛ ХАРИУЦАГЧ

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС

БОХАБЭА ХЭЛТЭС

ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ХАРИУЦАГЧ

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

МАРКЕТИНГИЙН АЛБА

ҮНДСЭН ЭРСДЭЛ ХАРИУЦАГЧ

ХУДАЛДАН АВАЛТЫН ХЭЛТЭС

ЭРСДЭЛ ХЯНАГЧ БӨГӨӨД МЭДЭЭЛЭГЧ

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС

Гүйцэтгэх түвшин

ЁС ЗҮЙН ХОРОО

Нийт ажилтнууд нь “Дэлхийн хөгжлийг Монголдоо цогцлоох” эрхэм зорилго болон бизнесийн бусад зорилго, зорилтондоо хүрэхийн төлөө ажиллахдаа Группийн үнэт зүйлс, баримтлах зарчмуудыг болон тэдгээрээс урган гарсан Ёс зүйн дүрмийг мөрдлөг болгоно. Энэхүү дүрэм нь тус компанийн ажилтнуудын өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхойлж өгөх үндсэн зорилготой.



Ёс зүйн дүрмийг танилцуулсан, хүний тоо	2023
Нийт сургалт орсон цаг	372
Ёс зүйн дүрмийн мөрдөлтийн талаар хүлээн авсан санал хүсэлт	528.5 цаг
Speak out	6
QR, дотоод сувгаар	13
БСС	50
Гомдлын мөрөөр судалж залруулах арга хэмжээ авсан байдал	100%

ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ



Манай компани ISO 31000:2018 стандартад суурилсан эрсдэлийн удирдлагын тогтолцоо хэрэгжүүлдэг. Энэ нь бизнесийн салбарын онцлогоос үл хамааран бүх төрлийн эрсдэлийг удирдах нийтлэг хандлагыг бий болгох, үүний хүрээнд нарийвчилсан зохицуулалт бүхий эрсдэлийн менежментийн цогц тогтолцоо юм.

Эрсдэл аудитын хороонд улирал тутам гадаад болон дотоод нөлөөлөл, хүчин зүйлийг тооцон эрсдэлээ тайлагнадаг. Бүх ажилтнууд мэдээлэх боломжтойгоор хийгдсэн эрсдэл мэдээлэх аппликейшний хөгжүүлэлт хийгдэж, эрсдэлийг мэдээлэх QR-ийг бүх ажлын байрнуудад байршуулсан

Манай бизнесийн хувьд хамгийн чухал эрсдэл, хамгийн том боломжуудыг сайжруулахаар дараах томоохон төсөлд анхаарал хандуулан ажиллаж байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 5 жил тутам хийлгэж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна.





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА